ТАНИЛЦУУЛГА

*"Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийн төсөл боловсруулсан тухай*

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ийн ***Салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчимд:*** "өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах", ***Эдийн засгийн олон тулгуурт бүтэц хэсгийн 3.2.1.7-д:*** "........., судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлнэ", ***3.2.1.8-д:*** "Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхийг хөгжүүлнэ", ***зорилт 5-ийн II үе шат:*** (2021-2025) "Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2.5 хувь хүртэлх түвшинд хүргэх" зорилтыг дэвшүүлж, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2.36 дахь заалтын 2 дахь хэсэгт "шинжлэх ухааны паркийн байгуулах, ТЭЗҮ боловсруулах"-аар заасан.

Монгол Улсын Засгийн газраас сүүлийн 3 жилийн хугацаанд "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого", "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого", "Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр", "Үндэсний инновацийн шагнал олгох", "Инновацийн төсөлд грант олгох журам", "инновацийн төсөл бүртгэх" журмыг тус тус баталсан.

Гэсэн хэдий ч өнөөдөр Монгол улсад инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах эрх зүйн орчин бүрэн төлөвшөөгүй, инновацийн дэд бүтэц хөгжөөгүй, мэдлэг, технологи дамжуулах механизм бүрэлдээгүй, үр ашиг нь тодорхойгүй байна.

Үүнээс гадна шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх салбар, чиглэлд судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа хангалтгүй, эрдэм шинжилгээний байгууллага, инновацийн компаниуд, жижиг, дунд үйлдвэр, томоохон компаниудын хоорондын хамтын ажиллагааны уялдаа, механизм сул хөгжсөн ялангуяа төрийн зүгээс эдийн засгийн хөшүүрэг, дэмжлэг хангалтгүй,байна.

Мөн аж үйлдвэрийн технологийн түвшин доогуур, гадаадын технологиос ихээхэн хамааралтай, төрийн өмчийн үйлдвэрийн газруудын технологийн шинэ шийдлийг хүлээн авах сонирхол бага, судалгаа боловсруулалтын ажлын эрэлт ч тэр хирээр хангалттай түвшинд хүрч чадахгүй байна.

Иймд дээр дурьдсан хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт, инновацийг хөгжүүлэхтэй холбоотой бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор

*Төсөл*

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны ...... дугаар сарын .....-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

## "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II" -ийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

1. "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд /Ё.Баатарбилэг/-д үүрэг болгосугай.

3. "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийг хэрэгжүүлэх хүрээнд авах арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — У.ХҮРЭЛСҮХ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД — Ё.БААТАРБИЛЭГ

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өрсөлдөх чадвар бүхий мэдлэг шингээсэн бүтээгдэхүүн үйлчилгээний хэмжээ нэмэгдэж, инновацийн гарааны бизнес эрхлэгчдийн тоо өсөх зэрэг үр дүн гарна гэж үзэж байна.

## Хоер. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Эдийн засаг, нийгмийн тэргүүлэх салбарт үндэсний инновацийн тогтолцооны суурь бүтцийг хөгжүүлэх, инновацийн тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийг бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах;

2.2.2. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх;

2.2.3. Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.

## Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. Нэгдүгээр үе шат: 2020-2022 он

3.1.2. Хоёрдугаар үе шат: 2023-2024 он

3.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зорилтын хүрээнд:

3.2.1.1 Шинжлэх ухааны паркийн эрх зүйн орчныг бий болгож, холбогдох дүрэм журам, зохицуулалтыг бүрдүүлэх;

3.2.1.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан шинжлэх ухааны парк, инновацийн төвүүдийг байгуулах;

3.2.1.3 Судалгааны их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад түшиглэн нээлттэй судалгааны төв, лабораторийг байгуулах;

3.2.1.4 Шинжлэх ухаан, технологи, инновацийн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хүний нөөцийг нарийн мэргэшүүлэх, туршлага солилцуулах, давтан сургах арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.2.2. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.2.1. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл, экспортын гол нэр төрлийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, улс орны нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн үйл ажиллагаанд холбогдох суурь болон технологи, инновацийн судалгааг төрөөс тэргүүн ээлжинд дэмжих;

3.2.2.2. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувийн хэвшлийн компаниудын судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан зардлыг бүртгэх, тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

3.2.2.3. Үндэсний аж ахуйн нэгжүүд, үйлдвэрлэгчдэд судалгаа ба хөгжүүлэлтэд зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, эсхүл төрөөс татаасын бодлогоор дэмжих эрх зүй, зохицуулалтыг бий болгох;

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8. | бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | Хувийн хэвшлийн судалгаа ба хөгжүүлэлтэд зарцуулсан зардлын хэмжээ | хувь | - | 0,5 | 1,0 |
| 9. | | Шинээр байгуулагдсан гарааны компаний тоо | хувь | 37 | 60 | 80 |
| 10. | | Төрийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээний тоо | тоо | 10 | 25 | 40 |
| 11. | | Хөгжлийн банк болон ЖДҮДС-аас санхүүжилт авсан инновацийн ААН, гарааны компанийн тоо | тоо | - | 50 | 150 |
| 12. | 3. Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | Инновацийн тэргүүлэх чиглэлээр гадаад дотоодын хамтарсан төсөл хөтөлбөрийн тоо | тоо | 15 | 25 | 50 |
| 13. | | Гадаад дотоодын хамтарсан төсөл хөтөлбөрт хамрагдсан судлаачдын хувь | хувь | - | 10 | 20 |
| 14. | | Төрийн болон хувийн хэвшлийн нээлттэй мэдээллийн сангийн тоо | тоо | - | 3 | 8 |
| 15. | | Их дээд сургууль, судалгааны байгууллагад байгуулагдсан тогтвортой үйл ажиллагаа бүхий нээлттэй платформын тоо | тоо | - | 3 | 10 |
| 16. | | Патент, ашигтай загвар зэрэг оюуны өмчийн эрхийн хамгаалалт бүхий бүтээлтэй судлаачдын хувь | хувь | - | 1.0 | 1.5 |
| 17. | | Олон улсын оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээгдэхүүний тоо | тоо | - | 2 | 5 |

## Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилт

5.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. Гадаадын зээл, тусламж;
- 5.1.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн өөрийн хөрөнгө
- 5.1.5. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

## Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрт хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулан, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

------------------ oOo ------------------

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 1 дүгээр хавсралт

“ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-II” -ИЙН
БУСАД ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДАЖ БАЙГАА ЗҮЙЛ ЗААЛТ

## Нэг. МУ-ын үзэл баримтлал хоорондын уялдаа хамаарал

| № | “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II”-ийн зорилт | Монгол Улсын үзэл баримтлалууд | | | | | Уялдсан байдал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 2016 | Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2001 | Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал 1995 | Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 | Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал 2011 | |
| 1 | Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | 2.2.3-ийн зорилт IV: 2 үе шат | 4.7.2а<br>4.7.4а | 3/1 | 3.6.2.6 | 21.1<br>23.4<br>25.3 | 8 |
| 2 | Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | 2.1.3-ийн зорилт I,<br>2.1.5-ийн зорилтII,<br>2.3.2-ийн зорилт II: 1, 3 үе шат | 4.7.2б<br>4.7.3г | | 3.2.1.5,<br>3.2.1.7,<br>3.2.1.8<br>3.4.1.12<br>3.5.3.5<br>3.5.4.4<br>3.6.1.9 | 21.2<br>23.1<br>23.3 | 16 |
| 3 | Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | 2.2.3-ийн зорилт III: 3 үе шат,<br>Зорилт V; 1-3 үе шат | | 2/Зорилго | 3.2.2.4<br>4.1.7 | 23.6<br>25.4 | 9 |
| | Уялдсан заалтын тоо | **9** | **4** | **2** | **10** | **8** | **33** |

## Гурав. Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг хоорондын уялдаа хамаарал

| № | "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийн зорилт, арга хэмжээ | Холбогдох бодлогын баримт бичгүүдийн нийцэж байгаа зорилго, зорилтууд | | | | | | | | | Уялдсан байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого 2018 | Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого 2010 | Төрөөс шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого 2017 | Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /2015-2021/ 2015 | Төрөөс соёлын талаар баримтлах бодлого 2010 Төр хувийн хэвшлийн | Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025 он/ 2013 | Ногоон хөгжлийн бодлого 2014 | Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /2015-2025/ 2015 | Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, 2015 | |
| 1 | Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | 4.1.6<br>4.3.4<br>4.3.5<br>4.4.4-4.4.6 | 4.2.1.1<br>4.2.2.2<br>4.2.3.1-<br>4.2.3.6 | 2.2.4<br>2.2.5<br>4.1.7<br>4.4.3<br>4.4.4<br>4.5.1<br>4.5.4-4.5.7<br>4.6.3 | 4.2.1.8<br>4.2.7.5 | | 3.3.7<br>3.7.12 | | 5.1.2<br>5.1.4 | | 31 |
| 2 | Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | 2.2.1-2.2.4<br>4.2.1-4.2.5<br>4.3:2-4.3.3<br>4.4.3 | 4.2.1.4<br>4.2.1.5<br>4.2.5.3<br>4.2.5.5 | 4.1.6<br>4.2.2-<br>4.2.4<br>4.4.5<br>4.6.2<br>4.6.4 | 4.2.4.2<br>4.2.5.1<br>4.2.5.2<br>4.2.5.3<br>4.2.6.1<br>4.2.7.4 | 4.1.8 | 3.2.1.4<br>3.3.4<br>3.3.6<br>3.4.3<br>3.4.4 | 3.1.8<br>3.3.4<br>3.5.5 | 1.4.4<br>6.1.6 | 3.1.5<br>3.2.5.2<br>4.1.2.5 | 43 |
| 3 | Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | 4.1.5<br>4.2.6<br>4.2.7<br>4.3.1<br>4.4.1<br>4.4.2 | 4.2.4.1<br>4.2.4.5<br>4.2.5.2<br>4.2.4.7 | 4.1.3<br>4.2.5<br>4.5.8 | 4.2.1.10<br>4.2.5.4<br>4.2.8.4 | 4.2.3<br>4.4.8 | 3.7.13 | | | | 19 |
| | Уялдсан заалтын тоо | 24 | 16 | 21 | 11 | 3 | 8 | 3 | 4 | 3 | **93** |

# "ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-II" -ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО

(сая төгрөгөөр)

| № | Хөтөлбөрийн зорилт | Эхлэх/ дуусах огноо | Нийт | 2020 | | | 2021 | | | 2022 | | | 2023 | | | 2024 | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт | Нийт шаардагдах санхүүжилт | Урсгал зардал | Хөрөнгө оруулалт |
| 1 | Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | 2020-2024 | 1,180,500.0 | 871,000.0 | - | 871,000.0 | 307,000.0 | 1,000.0 | 306,000.0 | 1,000.0 | 1,000.0 | | 1,000.0 | 1,000.0 | | 500.0 | 500.0 | - |
| 2 | Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | 2020-2024 | 77,000.0 | 11,400.0 | 11,400.0 | - | 13,400.0 | 13,400.0 | - | 15,400.0 | 15,400.0 | - | 17,400.0 | 17,400.0 | - | 19,400.0 | 19,400.0 | - |
| 3 | Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | 2020-2024 | 26,000.0 | 1,500.0 | 1,500.0 | - | 4,000.0 | 2,000.0 | 2,000.0 | 5,500.0 | 2,500.0 | 3,000.0 | 7,000.0 | 3,000.0 | 4,000.0 | 8,000.0 | 3,000.0 | 5,000.0 |
| Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ | | | **1,283,500.0** | **883,900.0** | **12,900.0** | **871,000.0** | **324,400.0** | **16,400.0** | **308,000.0** | **21,900.0** | **18,900.0** | **3,000.0** | **25,400.0** | **21,400.0** | **4,000.0** | **27,900.0** | **22,900.0** | **5,000.0** |
| Санхүүжилтийн эх үүсвэр | | | | | | | | | | | | | | | | | | |
| Улсын төсөв | | | 1,268,850.0 | 883,400.0 | 12,900.0 | 870,500.0 | 322,250.0 | 16,400.0 | 305,850.0 | 18,900.0 | 18,900.0 | - | 21,400.0 | 21,400.0 | - | 22,900.0 | 22,900.0 | - |
| Орон нутгийн төсөв | | | 14,000.0 | - | | | 2,000.0 | | 2,000.0 | 3,000.0 | | 3,000.0 | 4,000.0 | | 4,000.0 | 5,000.0 | | 5,000.0 |
| Гадаадын зээл, тусламж | | | 650.0 | 500.0 | - | 500.0 | 150.0 | - | 150.0 | - | - | - | - | - | - | - | - | - |
| Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | | | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас | | | | | | | | | | | | | | | | | | |
| Концессын гэрээ | | | | | | | | | | | | | | | | | | |
| Бусад эх үүсвэр | | | | | | | | | | | | | | | | | | |

**Тайлбар:** МУ-ын 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, МУ-ын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт 2020-2024, 2020-2045 он хүртэлх төлөвлөгөөний төсөл, МУЗГ-ын 2018 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого"-ын 2 дугаар хавсралт зэрэгт тусгасан санхүүжилт, хөрөнгө оруулалтад үндэслэн тооцсон болно.

Хөгжлийн бодлогын баримт бичиг
боловсруулах нийтлэг журмын 3 дугаар хавсралт

# "ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-II" -ийн хэлэлцүүлгийн саналын багц, товьёог

| № | Хөтөлбөрийн холбогдох зорилго, зорилт | Санал гаргасан | | | | Саналыг тусгасан байдал |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нэмэлт оруулах | Хасах | Өөрчлөх | Найруулах | |
| I. | "Үндэсний инновацийн форум" үндэсний чуулганд оролцогчдын санал, зөвлөмж (2018-2019 он) | | | | | |
| 1.1 | Үндэсний инновацийн ,тогтолцооны суурь дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | - Хууль, холбогдох дүрэм журам зэрэг эрхзүйн орчны шинэчлэлийг хурдасгах<br>- Инновацийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн санг байгуулах, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих.<br>- Инженерийн боловсрол олгох суурь мэдлэгийг нэмэгдүүлэх, байгалийн ухааны лабораторийг шинэчлэх,<br>- Өндөр технологи, аж үйлдвэр, шинжлэх ухааны парк зэрэг кластерийн дэд бүтцийг хөгжүүлэх | - | - Хууль эрх зүйн орчныг хөгжлийн урт хугацааны бодлоготой уялдуулан тогтвортой байхаар хуульчлах. | - Шинжлэх ухаан технологи, инноваци, үйлдвэржилт, дэд бүтэц, хүн амын төвлөрөл, эдийн засгийн өрсөлдөх чадварыг харгалзан үзэж эрх зүйн шинэчлэлийг хийх;<br>- Экспортыг урамшуулах бодлого баримтлах; | Саналыг судлан үзэж, зарчмын хувьд шаардлагатай агуулгыг хөтөлбөрийн төсөлд тусгасан. |
| 1.2 | Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | - Инновацийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох<br>- Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх<br>- Инновацийн бүтээлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулахад шаардлагатай технологи, үйлчилгээг нэмэгдүүлэх, дэмжих.<br>- Инновацийн үйл ажиллагаа, гарааны компани байгуулах зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэх | - | - | - Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, тогтвортой, өндөр үр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөөс дэмжих;<br>- Инновацийн дэд бүтцийн нэг болох технологийн компанийг дэмжих;<br>- Олон улсын маркетинг яаж хийх вэ? Брэнд бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр яаж маркетинг хийх;<br>- Инноваци хийх, хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг харгалзан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг | Хөтөлбөрийн төслийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны концепцтэй санал давхцаж байгаа тул туссан гэж үзэж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - оюуны өмчийн ойлголт, инновацийг хөгжүүлэх сэтгэлгээг дээшлүүлж ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт нэмж оруулах<br>- Технологи дамжуулалтын хүрээнд хагас үйлдвэрлэлийн туршилт хийх, цех байгуулахад хувийн байгууллагын оролцоо, идэвх санаачилгыг дэмжих | | | | |
| **II.** | **Төрийн болон төрийн бус байгууллагуудын өгсөн санал (2018-2019 он)** | | | | | |
| 2.1 | Үндэсний инновацийн ,тогтолцооны суурь дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | - Инноваци бол үйлдвэрлэлийн орчинд хөгждөг. Иймд үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжсэн цогц хууль эрх зүйн зохицуулалтыг нэн тэргүүнд хийх;<br>- Оюуны өмчийг эргэлтэнд оруулах гол зүйл бол хууль эрх зүйн орчин. Энэ байхгүй бол яагаад ч хөгжихгүй, төр зөвхөн үүнд л анхаарах; | - | - | - | Санал туссан. |
| 2.2 | Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | - Үйлдвэрлэлээс гарсан бүтээгдэхүүнд борлуулалтын зах зээлийг бий болгож татварын зохицуулалт хийж өгөх;<br>- Гарааны компаниудыг дэмжиж ажилладаг. Төр үүний адил төвүүд байгуулах, гарааны компанийг дэмжих;<br>- Судалгаа хөгжүүлэлтийг дэмжих<br>- Инновацийн тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхой улс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлд баримжаалан тодорхойлж, тэдгээрт хөрөнгө, нөөц бүхийл үйл ажиллагааг төвлөрүүлэх, хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх нөхцлөөр хангах. | - | - | - Үндэсний компаниудыг тэргүүн ээлжинд дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэ санаа, техонлогийг дэлхийн зах зээлд гаргах нөхцлөөр хангах | Саналыг судлан үзэж, холбогдох саналыг тусгасан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | - Их дээд сургуультай хамтарсан болон захиалгат судалгааг эрчимжүүлэх<br>- Судалгаанд суурилсан их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, аж үйлдвэрийн уялдаа холбоог бэхжүүлэх, хөгжүүлэх.<br>- Тоног төхөөрөмж хангалтгүй, өртөг өндөр, татвар, гаалиар нэвтрүүлэхэд хүндрэл дарамт ихтэй | | | | уялдуулж хөгжүүлэх боломжийг бүрүүлэх үүднээс уг хөтөлбөрийн төслийг боловсруулсан. |
| 3.3 | Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | - Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх<br>- Татварын дарамт их, патент, тусгай зөвшөөрөл авахад хүндрэлтэй<br>- мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх<br>- Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад хувийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах | - | - | - | Саналыг тусгасан. |
| **IV.** | **Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулах Ажлын хэсэг /БСШУСЯ, ШУА, МУИС, ШУТИС, Шинэ Монгол технологийн дээд сургууль, Старт-ап терминал ХХК, Старт-ап Монголиа ТББ-ийн төлөөлөл/-ийн саналыг тусгасан байдал (2019 он)** | | | | | |
| 4.1 | Ерөнхий санал | Хөтөлбөрийн төслийг хөгжлийн бодлогын баримт бичгийн бүтцийн дагуу зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа байдлаар томьёолохоор нэгдсэн санал гарч, зарчмын хувьд инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх салбар, чиглэл болон шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар маш тодорхой 3-5 жилийн хугацаанд хэрэгжих боломжтой байхаар томьёолохоор санал нэгдэн боловсруулсан. | | | | |
| 4.2 | Хөтөлбөрийн зорилго | - | - | - Эдийн засаг, нийгмийн тэргүүлэх салбарт үндэсний инновацийн тогтолцооны суурь бүтцийг хөгжүүлэх, инновацийн тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, | - | Саналыг бүхэлд нь тусгасан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг хөгжүүлэх | - Өндөр технологи шингэсэн буюу экспортыг бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн дэмжлэгүүдийг тодорхой тусгах<br>- Экспортын баримжаатай, орчин үеийн оюуны багтаамж бүхий, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх судалгаа, шинжилгээний ажлуудыг дэмжих, төрөөс санаачлан хэрэгжүүлэх;<br>- Олон улсын стандарт, дэвшилтэт технологийг нутагшуулсан, өндөр бүтээмжтэй, олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай, инновацийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг дэмжих, татварын хөнгөлөлт, татаасын дэмжлэг үзүүлэх. | | суурь болон технологи, инновацийн судалгааг төрөөс тэргүүн ээлжинд дэмжих;<br>- Инновацийн тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнест Хөгжлийн банк, Жижиг дунд, үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон Засгийн газрын бусад сангаас нэн тэргүүнд санхүүжилт хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, төрийн бодлогоор онцгойлон дэмжих | - Төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувийн хэвшлийн компаниудын судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан зардлыг бүртгэх, тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;<br>- Үндэсний аж ахуйн нэгжүүд, үйлдвэрлэгчдэд судалгаа ба хөгжүүлэлтэд зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, эсхүл төрөөс татаасын бодлогоор дэмжих эрх зүй, зохицуулалтыг бий болгох;<br>- Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, шат дамжлагагүй хүргэх цахим үйлчилгээ, контентыг нийгмийн үйлчилгээний салбар бүрт нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах; | |
| 4.6 | Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | - Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй түргэн шуурхай хүргэхэд чиглэсэн инновацийн үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх.<br>- Инновацийн тэргүүлэх чиглэлээр гадаад, дотоодын эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх судалгаа, төсөл, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх. | - | - Гарааны компани, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа, дэд бүтэц, хүний нөөцийн хөгжүүлэхтэй холбоотой нээлттэй платформ, мэдээллийн санг байгуулах;<br>- Мэдээллийн технологид суурилсан инновацийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх.<br>- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийн эрхийн хамгаалалт, нийтэд сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | - Мэдээллийн технологид суурилсан инновацийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх<br>- Хувийн хэвшил, судалгааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай хамтран тэргүүн ээлжинд боловсруулах үйлдвэрийн салбарын экспортын гол нэр төрлийн 3-4 брэнд бүтээгдэхүүнд олон улсын оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийх ажлыг зохион байгуулах. | Саналыг тусгасан. |

# “ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-II” -ИЙН НӨЛӨӨЛЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

<table>
<tr><th colspan="2">А. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл</th></tr>
<tr><td>1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлэх зорилтот бүлэг болон бусад бүлэг</td><td>Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр –II (цаашид хөтөлбөр гэх) хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдалд шууд болон шууд бусаар нөлөөлөх нийгмийн зорилтот бүлгүүд:<br>- Төр, засгийн байгууллагууд (Монгол Улсын Засгийн газар, БСШУСЯ, бусад яамд, агентлагууд)<br>- Шинжлэх ухаан, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд (ШУА, эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиуд)<br>- Бизнесийн байгууллагууд (Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагууд, инновацийн үйл ажиллагаа эрхэлж буй гарааны компани)<br>- Зуучлагчид буюу түншлэлийг дэмжих байгууллагууд (Мэдлэг, технологи дамжуулах, нутагшуулах, бойжуулах, хөрөнгө оруулалт татах, судалгааны ажлын үр дүнг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагууд)<br>- Иргэд, олон нийт (хүн ам, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагууд)<br>Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:<br>1. <u>Төр, засгийн байгууллагууд (Монгол Улсын Засгийн газар, БСШУСЯ, бусад яамд, агентлагууд)</u>-ын хувьд:<br>- Шинжлэх ухаанд суурилсан инноваци технологийг Монгол улсын нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх үндсэн хүчин зүйл болгох чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тогтвортой байх, уялдааг хангах, инновацийн олон талт арга хэмжээ хэрэгжүүлэхэд баримтлах чиг баримжаа, эрх зүйн үндэслэл болно.<br>- Хөтөлбөрийг үр дүнтэй тууштай хэрэгжүүлэхэд улс төрийн тогтворгүй байдал, төр, засгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, томилгоо, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдал зэрэг хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.<br>2. <u>Төр хувийн хэвшлийн тогтвортой хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизм бүрдсэнээр:</u><br>- Инноваци, өндөр технологийн үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төр-хувийн хэвшлийн хамтын түншлэлийг бэхжүүлэх, инновацийн төсөл арга хэмжээг олон талт эх үүсвэрээс санхүүжүүлэх нөхцөл бүрдэнэ.<br>- Шинэ бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ зах зээлд нэвтрэх, инновацийн төслийн болон судалгаа хөгжүүлэлтийн ажил, туршин нэвтрүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх таатай нөхцөл бий болно.<br>- Эрдэмтэн судлаач, инженерүүдийн чадавхийг бэхжүүлэх тогтвортой үйл ажиллагааны болон санхүүжилтийн тогтолцоо бүрдэнэ.<br>- Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нягтаршиж, харилцан дэмжлэг үзүүлэх, төрөөс аж ахуйн нэгж, гарааны компанид инновацийн бүтээгдэхүүнийг туршин нэвтрүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих боломж нөхцөл, суурь тавигдана.<br>3. <u>Шинжлэх ухаан, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд (ШУА, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиуд)</u>-ын тухайд:</td></tr>
</table>

| | |
|---|---|
| 2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө | 1. Инновацийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010), Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011), Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал (1995), Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001), Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (2016) зэрэг 5 үзэл баримтлал, Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогод тусгасан зорилт, зүйл заалтууд хэрэгжих боломжтой.<br>2. Хөтөлбөрийн хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс дараах үр нөлөө бий болно. Үүнд:<br>- Хөтөлбөрийг баталж хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжлийн хувьд шинжлэх ухаан, инноваци, технологийн салбар нь зах зээлийн эрэлт-нийлүүлэлт, хэрэгцээ-шаардлагад нийцсэн, эдийн засаг, нийгмийн тогтвортой өсөлтийг хангах, хөгжлийн шинэ түвшинд гарах, цаашдын хөгжлийн захиалгад нийцсэн өрсөлдөх чадвар бүрэлдэх, үүний зэрэгцээ хууль эрх зүйн хувьд одоо мөрдөгдөж буй эрх зүйн зарим баримт бичгийг хөтөлбөрт нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох, хоорондын уялдаа холбоо хангагдах боломж тус тус бүрдэнэ.<br>- Инноваци, технологийн судалгааны мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сүлжээ, сан бий болж, туршилт судалгаа, лабораторийн орчин сайжирч, олон улсын чиг хандлагад нийцсэн инновацийн дэд бүтэц бий болсноор судалгаа боловсруулалтын ажлын түвшин, чанар дээшилж, нийгэм, эдийн засгийн үр өгөөж нэмэгдэнэ. Мөн технологийн бирж, инкубатор ажилласнаар оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл боломж бүрдэнэ.<br>- Гадаадад ажиллаж буй эрдэмтэн судлаачдыг өөрийн орны судалгаанд татан оролцуулах, залуу судлаачдыг дэмжсэн судалгааны тэтгэлэг, дэмжлэг, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх тогтвортой тогтолцоо, механизм бий болно.<br>- Инновацийн үйл ажиллагаанд хувийн хэвшил, бизнесийн оролцоо нэмэгдэж, судалгаа боловсруулалтын ажилд зарцуулах төсвийн бус санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэнэ.<br>- Стратегийн түншлэл, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлснээр шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарын гадаад хамтын ажиллагаа тогтвортой хөгжих, олон улсын болон гадаад орны шинжлэх ухаан, инноваци, технологийн байгууллагын дэд бүтцийг түшиглэн судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх, олон улсын нэр хүндтэй эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан туршилт судалгааны төв, инкубатор, парк, лаборатори байгуулж ажиллах боломж бүрдэж, эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ажлын гүйцэтгэл, үр дүн олон улсын стандарт түвшинд хүрнэ.<br>- Технологийн инкубатор, технологи дамжуулах төв, бизнес инкубатор, хурдасгуур компани, шинжлэх ухааны парк байгуулагдсанаар дотоодын нийт бүтээгдэхүүнд өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ нэмэгдэнэ.<br>- Оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар баялаг бүтээх үйл явцыг хурдасгаж, судалгаа-сургалт-үйлдвэрлэл гэсэн цогц байдлаар хөгжүүлснээр улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахад ахиц дэвшил гарна.<br>- Аж үйлдвэрийн үндсэн салбаруудын технологи хөгжүүлэх, дамжуулах, нутагшуулах чадвар дээшилж, тэдгээрийг тогтвортой хөгжүүлэхүйц, глобал эдийн засгийн технологийн эрэлт, өөрчлөлтөд үр дүнтэй зохицох чадавх сайжирна.<br>- Тэргүүний, дэвшилтэт технологийг хөгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн технологийн бааз суурийг шинэчлэн бэхжүүлэх боломж бүрдэнэ. |

өрсөлдөх чадвартай ажиллах хүчнийг болон судалгаа боловсруулалтын ажлыг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх өрсөлдөх боломжтой болно.

- Аж ахуйн нэгж, байгууллага - Улс орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөллийг үзүүлж, эдийн засгийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлнэ. Чанартай бараа, ажил, үйлчилгээг дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэхийн тулд харилцан хамтран ажиллана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгмийн хөгжилд дараах сөрөг үр нөлөө үүсэхээс сэргийлэх шаардлагатай. Эдгээр нь:

- Инновацийн туршилт судалгаа, боловсруулалтын чиглэлд хувийн секторын оролцоог хангахгүй, бодитой дэмжихгүй тохиолдолд гаднаас өндөр технологийг нутагшуулж чадахгүй байх, хугацаа алдах;
- Инновацийн туршилт судалгаа, боловсруулалтын ажлын санхүүжилт, удирдлагын тогтолцоонд өөрчлөлт хийхэд цаг алдвал эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн үйл аижллагаа эрхэлж буй байгууллагуудын үйл ажиллагаа, менежмент алдагдах, хөгжихгүй байх;
- Үр ашигтай оюуны хөрөнгө оруулалт, бүтээмжийг оновчтой үнэлэх тогтолцоо бүрдэхгүй, чадварлаг судлаач, эрдэмтэд бизнес, хувийн салбар руу шилжих, судлаачдын мэдлэг, чадварын түвшинд ахиц гархагүй байх, судлаачдын залгамж халаа тасрах, залуу судлаачид гадаадад ажиллах, эргэж ирэхгүй байх сонирхол давамгайлах, улмаар гадагш чадвартай шилдэг боловсон хүчнээ алдах;
- Судалгаа, сургалтын үйл ажиллагааны түншлэл хэрэгжихгүй бол эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулиуд лабораторийн тоног төхөөрөмжийг хамтран ашиглах боломж хязгаарлагдаж, туршилт судалгааны лабораторийн ашиглалт хангалтгүй болох;
- Үндэсний инновацийн суурь тогтолцоо бүрэлдэн бэхжихгүй удаашрах тохиолдолд инновацийн үйл ажиллагаа, туршилт судалгааны ажлын үр дүн, чанар буурах, практикт нэвтрэх боломж, цаг хугацаа алдах, эдийн засгийн эргэлтэд орохгүй байх, инновацийн үйл ажиллагаанд үйлдвэр, аж ахуйн нэгж, бусад байгууллагуудын оролцоо сулрах, бизнес эрхлэгчид дотоодын нөөц бололцоог ашиглахгүй байх;
- Инновацийн үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагаа хөгжихгүй байх, гадны байгууллагууд Монголын эрдэмтэдтэй хамтран ажиллах сонирхол буурах, ялангуяа гадаадын технологи, техник аж үйлдвэрлэл тодорхой салбарт давамгайлж, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх;
- Оюуны өмчийн эрхийн маргаан үүсэх, ЭШБ, судлаачид патентаас олох боломжтой ашиг алдагдах.

Боломж, арга зам:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох, хууль хоорондын уялдааг нягт хангах;
- Инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагааны суурь бүтцийг бүрдүүлэн бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг хангах;
- Туршилт судалгаа, инновацийн үйл ажиллагааны үр дүнг ашиглах, хамгаалах эрх зүйн орчин, институцчлэгдсэн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх;
- Үйлдвэрлэл, технологийн инновацид түшиглэн эдийн засгийг шинэчлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах;
- Инноваци, технологийн үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

| | |
|---|---|
| 3. Бусад мэдээлэл | Энэхүү нөлөөллийн үнэлгээний “Б”-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн талаар энд бичиж болно. |
| **В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө** | |

| | |
|---|---|
| өнөөгийн институцийг татан буулгах, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулах) | 3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад аливаа нэгэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай тохиолдолд тус байгууллагын чиг үүрэг хэрхэн өөрчлөгдөх, тодорхой чиг үүргийг тухайлбал, бүс, орон нутгийн байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болохгүй талаар тайлбарлан бичнэ.<br>- *Шаардлагагүй*<br>4. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судалж бичнэ.<br>- *Шаардлагагүй.*<br>5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломжийг судалж бичнэ.<br>- *Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг олон талт хэлбэрээр хөгжүүлэх бүрэн боломжтой.* |
| 3. Хүний нөөцөд үзүүлэх нөлөө | Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхид өөрчлөлт оруулахгүйгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар бичнэ.<br>- *Боломжтой.* Учир нь одоогийн байгаа нөөц бололцоондоо тулгуурлан төр хувийн хэвшлийн байгууллагын хүний нөөцийн чадавхийг олон талт хэлбэрээр бэхжүүлнэ. Тухайлбал: Инноваци, технологийн салбарт мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэхдээ сонгон шалгаруулах зарчмаар дотоод гадаадад мэргэшүүлэх боломжийг бүрдүүлэхээр судалгаанд суурилсан их сургуулийн хөтөлбөр, шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрүүдэд тодорхой зүйл, заалт бүхий зохицуулалтыг тусгасан. Иймд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхид өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжих бүрэн боломжтой. |

-------------------------------oOo------------------------------

## "ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-II" -ИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | Бодлогын зорилт | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Мэдээллийн эх сурвалж | Хэрэгжүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2019 | 2022 | 2024 | | |
| 1 | 1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах; | Шинжлэх ухааны паркийг хөгжүүлэхтэй холбоотой шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулан батлах эрх зүйн баримт бичгийн тоо | тоо | 1 хууль, 2 журам | 3 хууль, 3 журам | 3 хууль, 5 журам | Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх нөхцөл байдлын судалгааны тайлан МУ-д 2018-2019 он<br><br>Үндэсний статистикийн хорооны 2018-2019 оны тайлан<br><br>Шинжлэх ухаан, технологи, инновацийн эрх зүй, бодлогын орчны чадавхийг бэхжүүлэх нь төслийн тайлан 2018-2019 он | • Төр, засгийн байгууллагууд (Монгол Улсын Засгийн газар, БСШУСЯ, бусад яамд, агентлагууд)<br>• Шинжлэх ухаан, боловсролын байгууллагууд (ШУА, эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, их сургуулиуд)<br>• Бизнесийн байгууллагууд (гарааны компани, инновацийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд)<br>• Зуучлагчид буюу түншлэлийг дэмжих байгууллагууд |
| 2 | | Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах шинжлэх ухааны парк, инновацийн төвийн тоо | тоо | - | 2 | 4 | | |
| 3 | | Олон улсын итгэмжлэл бүхий нээлттэй судалгааны төв, лабораторийн тоо | тоо | - | 5 | 10 | | |
| 4 | | Гадаадад мэргэшил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамрагдсан судлаачдын хувь | хувь | - | 9 | 12 | | |
| 5 | | Гадаад, дотоодын эрдэмтэн солилцооны хөтөлбөрт хамрагдсан судлаачдын хувь | хувь | 9 | 12 | 13 | | |
| 6 | | Оюуны өмч, патент судлал, инновацийн менежмент, маркетингийн чиглэлээр гадаад, дотоодод мэргэшсэн мэргэжилтний эзлэх хувь | хувь | - | 0.5 | 2 | | |
| 7 | 2. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх; | Инновацийн тэргүүлэх салбар, чиглэлийн суурь болон технологи, инновацийн судалгаанд төрөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээ | сая төг | - | 2000 | 5000 | | |
| 8 | | Хувийн хэвшлийн судалгаа ба хөгжүүлэлтэд зарцуулсан зардлын хэмжээ | хувь | - | 0,5 | 1,0 | | |
| 9 | | Шинээр байгуулагдсан гарааны компаний тоо | хувь | 37 | 60 | 80 | | |
| 10 | | Төрийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээний тоо | тоо | 10 | 25 | 40 | | |
| 11 | | Хөгжлийн банк болон ЖДҮДС-аас санхүүжилт авсан инновацийн ААН, гарааны компанийн тоо | тоо | - | 50 | 150 | | |
| 12 | 3. Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх; | Инновацийн тэргүүлэх чиглэлээр гадаад дотоодын хамтарсан төсөл хөтөлбөрийн тоо | тоо | 15 | 25 | 50 | | |
| 13 | | Гадаад дотоодын хамтарсан төсөл хөтөлбөрт хамрагдсан судлаачдын хувь | хувь | - | 10 | 20 | | |
| 14 | | Төрийн болон хувийн хэвшлийн нээлттэй мэдээллийн сангийн тоо | тоо | - | 3 | 8 | | |
| 15 | | Их дээд сургууль, судалгааны байгууллагад байгуулагдсан тогтвортой үйл ажиллагаа бүхий нээлттэй платформын тоо | тоо | - | 3 | 10 | | |
| 16 | | Патент, ашигтай загвар зэрэг оюуны өмчийн эрхийн хамгаалалт бүхий бүтээлтэй судлаачдын хувь | хувь | - | 1 | 1.5 | | |
| 17 | | Олон улсын оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээгдэхүүний тоо | тоо | - | 2 | 5 | | |

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 6 дугаар хавсралт

“Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II” -ийг
хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

| Бодлогын чиглэл | | ***1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлж, хүний нөөцийг чадавхжуулна.*** | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
| 1.1 | Шинжлэх ухааны паркийн эрх зүйн орчныг бий болгож, холбогдох дүрэм журмыг шинэчилж, зохицуулалтыг бүрдүүлнэ. | Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох 10 журмыг УИХ, ЗГ-т өргөн мэдүүлж батлуулсан байна. | Батлуулсан эрх зүйн баримт бичгийн тоо | БСШУСЯ Судалгааны их сургуулиуд | Холбогдох яам, агентлагууд, ШУПЗ, ШУТС АНЗДТГ | 2019-2024 |
| 1.2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан шинжлэх ухааны парк, инновацийн төвийн кластер, технологийн биржийг / Дархан, Эрдэнэт, Сайншанд, Ховд, Дорнод зэрэг томоохон хотуудад/ байгуулна. | 2022 он гэхэд 2, 2024 он гэхэд 4 шинжлэх ухааны парк, технологийн бирж, инновацийн кластер, төвүүд байгуулагдсан байна. | Байгуулагдсан шинжлэх ухааны парк, технологийн бирж, инновацийн төв, кластерийн тоо | БСШУСЯ Судалгааны их сургуулиуд /төр-хувийн хэвшлийн/ | | 2022-2024 |
| 1.3 | Судалгааны их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад түшиглэн нээлттэй судалгааны төв, лабораторийг байгуулна. | Дундын ашиглалттай лаборатори, салбар дамнасан олон улсын итгэмжлэл бүхий өндөр технологийн нээлттэй судалгааны төв, лабораторийг 2022 он гэхэд 5, 2024 он гэхэд 10-ийг байгуулсан байна. | Лабораторийн орчин, судалгааны түвшин дээшилсэн байна.<br><br>Байгуулагдсан нээлттэй судалгааны төв, лабораторийн тоо | БСШУСЯ | ШУА, ШУТС Судалгааны их сургуулиуд | 2020-2024 |
| 1.4 | Шинжлэх ухааны парк, инновацийн төвүүдэд ажиллах мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ. /инновацийн тэргүүлэх салбар, | Инновацийн тэргүүлэх 5 салбар, чиглэлд хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх сургалтын тогтолцоо бүрдсэн байна. | Гадаадад мэргэшил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамрагдсан судлаачдын хувь | | ШУПЗ Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, | 2020-2024 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн хамтарсан төсөл, хөтөлбөрийг аймаг, нийслэл, орон нутаг, бүсийн түвшинд хэрэгжүүлнэ. | | төрөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээ | | АНЗДТГ | |
| 2.3 | Аж үйлдвэрийн болон эдийн засгийн тэргүүлэх салбарын технологийн судалгаа боловсруулалтыг дэмжин хөгжүүлнэ. | Захиалгат болон зорилтот, инновацийн төслүүдийг хэрэгжүүлсэн байна. | Үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтэрсэн технологи, инновацийн тоо Хэрэгжүүлсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ | БСШУСЯ | Холбогдох яам, ШУА, эрдэм шинжилгээний хүрээлэн төв ШУПЗ | 2020-2024 |
| 2.4 | Төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувийн хэвшлийн компаниудын судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан зардлыг бүртгэх, тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | Холбогдох чиглэлийн яам, агентлагтай хамтран эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.<br>Судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан зардлыг бүртгэх, тооцох тогтолцоо нэвтрүүлсэн байна. | Хувийн хэвшлийн судалгаа ба хөгжүүлэлтэд зарцуулсан зардлын хувь хэмжээ | | Сангийн яам, ХДХЯ МҮХАҮТ УБЕГ МХХТГ ТЕГ | |
| 2.5 | Үндэсний аж ахуйн нэгжүүд, үйлдвэрлэгчдэд судалгаа ба хөгжүүлэлтэд зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, эсхүл төрөөс татаасын бодлогоор дэмжих эрх зүй, зохицуулалтыг бий болгоно. | Өндөр технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ, чанар хүртээмж нэмэгдэнэ.<br>Дэвшилтэт технологи нэвтрүүлсэн нутагшуулсан аж ахуйн нэгжийг урамшуулах механизм бүрдэнэ. | Шинээр бамйгуулагдсан гарааны компаний тоо<br>Экспортын брэнд бүтээгдэхүүний тоо хэмжээ<br>Аж ахуйн нэгжид олгосон урамшуулал, санхүүжилт хөрөнгө оруулалтын тоо хэмжээ,<br>Гаалийн татвараас эдэлсэн хөнгөлөлт, санхүүжилтийн тоо /тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээ/ | БСШУСЯ | Холбогдох яам, Гаалийн болон Татварын ерөнхий газар | 2020-2024 |
| 2.6 | Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, шат дамжлагагүй хүргэх цахим үйлчилгээ, контентыг нийгмийн үйлчилгээний салбар бүрт нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. | Инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой бүхий л чиглэлийн мэдээллийн бааз бүрдэх суурь тавигдана.<br>Иргэд төрийн мэдээлэл | Төрийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо | БСШУСЯ | Холбогдох яам, ШУПЗ, чиглэлийн их дээд сургууль, | 2020-2024 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | Хувийн хэвшил, судалгааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай хамтран тэргүүн ээлжинд боловсруулах үйлдвэрийн салбарын экспортын гол нэр төрлийн 3-4 брэнд бүтээгдэхүүнд олон улсын оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийх ажлыг зохион байгуулна. | Экспортын гол нэр төрлийн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд олон улсын оюуны эрхийн хамгаалалт хийгдсэн байна. | Патент, ашигтай загвар зэрэг оюуны өмчийн эрхийн хамгаалалт бүхий бүтээлтэй судлаачдын тоо<br>Олон улсын оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээгдэхүүний тоо | БСШУСЯ | ШУА, Их, дээд сургууль, ШУТС | 2021-2024 |

-------------------------------oOo-------------------------------

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 9 дүгээр хавсралтын 1 дэх хүснэгт

## “ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-II” -ИЙН ЗОРИЛТУУДЫН ХООРОНДЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн зорилтууд | Зорилт 1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | Зорилт 2. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | Зорилт 3. Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | ДҮН /оноог мөрийн дагуу нэгтгэн гаргана/ |
|---|---|---|---|---|
| Зорилт 1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь, дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах | 3 | 2 | 3 | 8 |
| Зорилт 2. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | 3 | 3 | 3 | 9 |
| Зорилт 3. Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | 3 | 3 | 3 | 9 |

---oOo---

| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Үндэсний инновацийн тогтолцооны суурь дэд бүтцийг ,хөгжүүлэх хүний нөөцийг чадавхжуулах | 1 | 2 | 0 | 0 | 3 | 1 | 0 | 2 | 1 | 2 | 3 | 2 | 0 | 2 | 2 | 0 | 2 | 1 | 2 | 26 |
| Зорилт 2. Инновацийн тэргүүлэх салбар, чиглэл болон төрийн, нийгмийн үйлчилгээнд инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх | 3 | 3 | 1 | 3 | 0 | 2 | 2 | 1 | 3 | 1 | 2 | 1 | 3 | 2 | 2 | 3 | 3 | 3 | 1 | 39 |
| Зорилт 3. Шинжлэх ухаан-судалгаа хөгжүүлэлт - үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | 3 | 3 | 0 | 2 | 0 | 3 | 1 | 2 | 2 | 1 | 2 | 2 | 1 | 0 | 0 | 2 | 3 | 2 | 0 | 29 |

----oOo----